



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Архангай аймгийн Хангай сумын Засаг даргын тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: АРА-2024/040/-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:  
[www.Open.audit.mn](http://www.Open.audit.mn)

Архангай аймаг  
2025 он

Дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа  
Утас: 7033-3141

Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn

Аудитын менежер Д.Нэргүйбаатар

Утас: 7033-2860

Цахим хаяг: Nerguibaatard@audit.gov.mn

Аудитор А.Пүрэвцэцэг

Цахим хаяг: purevtsetsega@audit.gov.mn

Утас: 9974-6363

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## 1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



### АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн захиргааны ордон, А корпус, 2 дугаар баг,  
Эрдэнэбулган сум, Архангай аймаг, 65139,  
Утас/Факс: (976) 7033 3141,  
Цахим шуудан: arkhangai@audit.gov.mn

2025. 02. 25 № 05  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-г

ХАНГАЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА  
М.БАТБОЛД ТАНАА

### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Архангай аймгийн Хангай сумын Засаг даргын тамгын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

### Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Улс төрийн албан хаагчдад нийт 9,012.2 мянган төгрөгийн үр дүнгийн урамшууллыг цалингийн сангаас олгосон нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна.

Дээрх зөрчил нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 16 дугаар зүйлийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1, 15 дугаар зүйлийн 15.1.3 дахь заалттай нийцэхгүй, тохиолдсон байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

### **Аудитын гол асуудал**

Тус байгууллага нь тайлант онд орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага хөтөлбөрийн хүрээнд 973,406.9 мянган төгрөгийн санхүүжилт авч, гүйцэтгэлээр 847,661.3 мянган төгрөгийг зарцуулж, 125,745.5 мянган төгрөг, өөрийн давсан орлогоос 26,493.1 мянган төгрөг нийт 152,238.6 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

### **Бусад асуудлын хэсэг**

Тус байгууллагын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 7 зорилтын хүрээнд 142 арга хэмжээг хэрэгжүүлэхээр боловсруулан 94 арга хэмжээ бүрэн хэрэгжиж, 28 арга хэмжээ 90-80 хувь, 13 арга хэмжээ 70-50 хувь, 5 арга хэмжээ 30 хувь, 2 хангалтгүй хэрэгжиж сумын Засаг дарга 90.4 хувьтай үнэлэгдсэн байна.

*Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.*

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.БАЙГАЛМАА

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Данс	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>I</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>112,940,519.40</u></b>	<b><u>71,482,931.40</u></b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b><u>27,548,750.00</u></b>	<b><u>2,416,000.00</u></b>
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	<b><u>27,548,750.00</u></b>	<b><u>2,416,000.00</u></b>
3352	Хувь хүмүүсээс авах авлага	27,548,750.00	2,416,000.00
<b>34</b>	<b>УРЬДЧИЛГАА</b>		
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b><u>44,566,769.40</u></b>	<b><u>53,066,931.40</u></b>
351	Түүхий эд материал	6,647,830.00	7,411,780.00
3511	Тусгай зориулалттай материал	6,380,830.00	7,144,780.00
3513	Эм боох материал	267,000.00	267,000.00
354	Хангамжийн материал	28,948,939.40	36,685,151.40
3541	Бичиг хэргийн материал	2,886,650.00	3,273,100.00
3542	Аж ахуйн материал	25,362,052.40	29,782,052.40
3544	Түлш, шатах тослох материал	668,738.00	3,600,000.00
3545	Барилгын засварын материал	31,499.00	29,999.00
356	Мал амьтад	8,970,000.00	8,970,000.00
<b>36</b>	<b>НӨӨЦИЙН БАРАА</b>	<b><u>40,825,000.00</u></b>	<b><u>16,000,000.00</u></b>
363	Тэжээлийн нөөц	40,825,000.00	16,000,000.00
<b>II</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>2,485,561,198.68</u></b>	<b><u>2,584,181,176.96</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b><u>2,485,561,198.68</u></b>	<b><u>2,584,181,176.96</u></b>
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b><u>2,406,289,198.68</u></b>	<b><u>2,505,584,176.96</u></b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	916,938,005.76	915,903,705.76
39202	Хуримтлагдсан элэгдэл	-58,063,611.80	-70,399,439.42
39203	Авто-тээврийн хэрэгсэл	372,653,885.00	517,710,552.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-168,720,512.88	-180,539,382.11
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	103,517,597.10	121,591,659.03
39206	Хуримтлагдсан элэгдэл	-65,490,204.62	-70,605,138.91
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	19,998,750.00	19,998,750.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-10,706,380.40	-11,605,408.72
39214	Бусад үндсэн хөрөнгө	1,764,673,121.25	1,764,673,121.25
39215	Хуримтлагдсан элэгдэл	-474,866,792.73	-507,499,583.92
39216	Дуусаагүй барилга, байгууламж	6,355,342.00	6,355,342.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b><u>79,272,000.00</u></b>	<b><u>78,597,000.00</u></b>
39301	Программ хангамж	2,650,000.00	2,650,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-2,650,000.00	-2,650,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	79,272,000.00	79,272,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл		-675,000.00
<b>III</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>2,598,501,718.08</u></b>	<b><u>2,655,664,108.36</u></b>
<b>IV</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>		<b><u>550,000.00</u></b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>		<b><u>550,000.00</u></b>
413	Өглөг		550,000.00
4136	Бусад өглөг		550,000.00
41361	Байгууллагад төлөх өглөг		550,000.00
<b>V</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>2,598,501,718.08</u></b>	<b><u>2,655,114,108.36</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b><u>2,598,501,718.08</u></b>	<b><u>2,655,114,108.36</u></b>

**Архангай аймгийн Хангай сумын ЗДТГ-ын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	353,817,116.23	353,817,116.23
51101	Өмч: - төрийн	353,817,116.23	353,817,116.23
512	Хуримтлагдсан үр дүн	2,178,666,654.06	2,235,279,044.34
5121	Өмнөх үеийн үр дүн	2,178,666,654.06	2,178,666,654.06
5122	Тайлант үеийн үр дүн		56,612,390.28
513	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	66,017,947.79	66,017,947.79
<b>VI</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>2,598,501,718.08</u></b>	<b><u>2,655,664,108.36</u></b>

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b><u>948,093,472.00</u></b>	<b><u>1,145,191,534.93</u></b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b><u>362,393,381.00</u></b>	<b><u>178,851,116.93</u></b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b><u>362,393,381.00</u></b>	<b><u>178,851,116.93</u></b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	22,037,750.00	16,360,355.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	22,037,750.00	16,360,355.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	320,362,631.00	159,674,461.93
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	19,993,000.00	2,816,300.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b><u>585,700,091.00</u></b>	<b><u>966,340,418.00</u></b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b><u>4,160,091.00</u></b>	<b><u>7,933,518.00</u></b>
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	1,500,000.00	6,050,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	408,000.00	
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,252,091.00	1,883,518.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b><u>581,540,000.00</u></b>	<b><u>958,406,900.00</u></b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	581,540,000.00	958,406,900.00
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b><u>793,174,005.36</u></b>	<b><u>1,088,530,398.41</u></b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b><u>793,174,005.36</u></b>	<b><u>1,088,530,398.41</u></b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b><u>757,115,071.22</u></b>	<b><u>908,119,310.64</u></b>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	398,091,414.00	577,524,918.47
210101	Үндсэн цалин	291,797,376.00	368,016,361.47
210102	Нэмэгдэл	81,365,559.00	176,045,171.00
210104	Урамшуулал	16,739,432.00	22,204,753.00
210105	Гэрээт ажлын хөлс	8,189,047.00	11,258,633.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	50,682,426.00	71,503,539.00
210201	Тэтгэврийн даатгал	34,463,974.00	48,624,446.00
210202	Тэтгэмжийн даатгал	4,054,639.00	5,720,523.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,314,576.00	4,576,421.00
210204	Ажилгүйдлийн даатгал	739,960.00	1,144,105.00
210205	Эрүүл мэндийн даатгал	8,109,277.00	11,438,044.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	13,642,209.26	13,835,717.26
210301	Гэрэл, цахилгаан	4,009,209.26	5,675,717.26
210302	Түлш, халаалт	9,588,000.00	8,120,000.00

**Архангай аймгийн Хангай сумын ЗДТГ-ын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

210303	Цэвэр, бохир ус	45,000.00	40,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	42,798,612.60	44,789,937.50
210401	Бичиг хэрэг	3,628,950.00	3,713,150.00
210402	Тээвэр, шатахуун	27,621,097.00	27,894,538.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,489,123.60	6,793,599.50
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	4,583,892.00	1,040,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,475,550.00	5,348,650.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,202,091.00	16,264,200.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,877,100.00	
210604	Урсгал засвар	5,324,991.00	16,264,200.00
2107	Томилолт, зочны зардал	17,108,200.00	20,839,000.00
210702	Дотоод албан томилолт	17,108,200.00	20,839,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,218,567.00	39,777,861.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,911,591.00	38,356,400.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	356,140.00	498,800.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	200,000.00	173,068.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	700,000.00	700,000.00
210807	Газрын төлбөр	50,836.00	49,593.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	221,371,551.36	123,584,137.41
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	23,419,250.00	42,647,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,835,000.00	4,431,800.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	192,117,301.36	76,505,337.41
212	ТАТААС	3,634,960.00	3,231,000.00
2122	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	3,634,960.00	3,231,000.00
212201	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	3,634,960.00	3,231,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	32,423,974.14	177,180,087.77
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,017,100.00	20,466,018.28
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг		19,746,018.28
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,017,100.00	720,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	29,406,874.14	152,238,661.49
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	29,406,874.14	152,238,661.49
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг		4,475,408.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг		4,475,408.00
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>154,919,466.64</b>	<b>56,661,136.52</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>		<b>48,746.24</b>
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз		48,746.24
<b>IV</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>		<b>-48,746.24</b>
<b>V</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>154,919,466.64</b>	<b>56,612,390.28</b>

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>607,737,841.00</b>	<b>1,007,833,523.00</b>

Архангай аймгийн Хангай сумын ЗДТГ-ын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b><u>22,037,750.00</u></b>	<b><u>41,493,105.00</u></b>
120	Нийтлэг татварын бус орлого	22,037,750.00	41,493,105.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	22,037,750.00	41,493,105.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	22,037,750.00	41,493,105.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b><u>585,700,091.00</u></b>	<b><u>966,340,418.00</u></b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b><u>4,160,091.00</u></b>	<b><u>7,933,518.00</u></b>
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	1,500,000.00	6,050,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	408,000.00	
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,252,091.00	1,883,518.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b><u>581,540,000.00</u></b>	<b><u>958,406,900.00</u></b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	581,540,000.00	958,406,900.00
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b><u>604,258,141.00</u></b>	<b><u>992,333,923.00</u></b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b><u>604,258,141.00</u></b>	<b><u>992,333,923.00</u></b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b><u>567,459,706.86</u></b>	<b><u>808,941,275.23</u></b>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	<u>398,091,414.00</u>	<u>577,524,918.47</u>
210101	Үндсэн цалин	291,797,376.00	368,016,361.47
210102	Нэмэгдэл	81,365,559.00	176,045,171.00
210104	Урамшуулал	16,739,432.00	22,204,753.00
210105	Гэрээт ажлын хөлс	8,189,047.00	11,258,633.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	<u>50,682,426.00</u>	<u>71,503,539.00</u>
210201	Тэтгэврийн даатгал	34,463,974.00	48,624,446.00
210202	Тэтгэмжийн даатгал	4,054,639.00	5,720,523.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,243,669.00	4,576,421.00
210204	Ажилгүйдлийн даатгал	810,867.00	1,144,105.00
210205	Эрүүл мэндийн даатгал	8,109,277.00	11,438,044.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	<u>13,642,209.26</u>	<u>19,021,717.26</u>
210301	Гэрэл, цахилгаан	4,009,209.26	5,675,717.26
210302	Түлш, халаалт	9,588,000.00	13,306,000.00
210303	Цэвэр, бохир ус	45,000.00	40,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	<u>35,792,295.60</u>	<u>34,431,929.50</u>
210401	Бичиг хэрэг	4,032,400.00	3,704,400.00
210402	Тээвэр, шатахуун	18,525,400.00	21,762,730.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,489,123.60	6,243,599.50
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	7,232,372.00	1,363,100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,513,000.00	1,358,100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	<u>10,749,990.00</u>	<u>14,052,000.00</u>
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,014,000.00	
210604	Урсгал засвар	9,735,990.00	14,052,000.00
2107	Томилолт, зочны зардал	<u>17,108,200.00</u>	<u>20,839,000.00</u>
210702	Дотоод албан томилолт	17,108,200.00	20,839,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	<u>4,558,882.00</u>	<u>43,773,271.00</u>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,251,906.00	42,351,810.00

**Архангай аймгийн Хангай сумын ЗДТГ-ын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

210804	Тээврийн хэрэгслийн татвар	356,140.00	498,800.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	200,000.00	173,068.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	700,000.00	700,000.00
210807	Газрын төлбөр	50,836.00	49,593.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	<u>36,834,290.00</u>	<u>27,794,900.00</u>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	30,999,290.00	23,363,100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,835,000.00	4,431,800.00
<b>212</b>	<b>ТАТААС</b>	<b><u>3,999,460.00</u></b>	<b><u>5,822,560.00</u></b>
2122	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	3,999,460.00	5,822,560.00
212201	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	3,999,460.00	5,822,560.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b><u>32,798,974.14</u></b>	<b><u>177,570,087.77</u></b>
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,392,100.00	20,856,018.28
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг		19,746,018.28
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,392,100.00	1,110,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b><u>29,406,874.14</u></b>	<b><u>152,238,661.49</u></b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	29,406,874.14	152,238,661.49
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг		4,475,408.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг		4,475,408.00
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b><u>3,479,700.00</u></b>	<b><u>15,499,600.00</u></b>
<b>V</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b><u>3,479,700.00</u></b>	<b><u>15,499,600.00</u></b>
	Дотоод эх үүсвэрээр	3,479,700.00	15,499,600.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	3,479,700.00	15,499,600.00
<b>VI</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b><u>-3,479,700.00</u></b>	<b><u>-15,499,600.00</u></b>
<b>VIII</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>		
<b>31</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
<b>31</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Д/Д	Үзүүлэлт	Засгийн газрын сан	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	ЗГ-н хувь оролцооны дүн
1	20... оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	353,817,116.23	66,017,947.79	2,178,666,654.06	2,598,501,718.08
7	Тайлант үеийн үр дүн			48,638,340.37	48,638,340.37
10	20... оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	353,817,116.23	66,017,947.79	2,178,666,654.06	2,598,501,718.08
17	Тайлант үеийн үр дүн			56,612,390.28	56,612,390.28
19	20... оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	353,817,116.23	66,017,947.79	2,235,279,044.34	2,655,114,108.36

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Д/Д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү дүн	Хувь
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>973,406,900.00</b>	<b>847,661,343.51</b>	<b>125,745,556.49</b>	<b>87.08</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>973,406,900.00</b>	<b>847,661,343.51</b>	<b>125,745,556.49</b>	<b>87.08</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>939,304,900.00</b>	<b>820,982,765.23</b>	<b>118,322,134.77</b>	<b>87.4</b>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	628,578,100.00	577,524,918.47	51,053,181.53	91.88
210101	Үндсэн цалин	614,178,100.00	368,016,361.47	246,161,738.53	59.92
210102	Нэмэгдэл		176,045,171.00	-176,045,171.00	
210104	Урамшуулал		22,204,753.00	-22,204,753.00	
210105	Гэрээт ажлын хөлс	14,400,000.00	11,258,633.00	3,141,367.00	78.18
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	78,572,300.00	71,503,539.00	7,068,761.00	91
210201	Тэтгэврийн даатгал	53,429,100.00	48,624,446.00	4,804,654.00	91.01
210202	Тэтгэмжийн даатгал	6,285,800.00	5,720,523.00	565,277.00	91.01
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,028,600.00	4,576,421.00	452,179.00	91.01
210204	Ажилгүйдлийн даатгал	1,257,200.00	1,144,105.00	113,095.00	91
210205	Эрүүл мэндийн даатгал	12,571,600.00	11,438,044.00	1,133,556.00	90.98
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	24,389,900.00	19,021,717.26	5,368,182.74	77.99
210301	Гэрэл, цахилгаан	9,000,000.00	5,675,717.26	3,324,282.74	63.06
210302	Түлш, халаалт	15,000,000.00	13,306,000.00	1,694,000.00	88.71
210303	Цэвэр, бохир ус	389,900.00	40,000.00	349,900.00	10.26
2104	Хангамж, бараа материалын зардал	38,700,000.00	34,431,929.50	4,268,070.50	88.97
210401	Бичиг хэрэг	5,000,000.00	3,704,400.00	1,295,600.00	74.09
210402	Тээвэр, шатахуун	22,000,000.00	21,762,730.00	237,270.00	98.92
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	7,200,000.00	6,243,599.50	956,400.50	86.72
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,000,000.00	1,363,100.00	1,636,900.00	45.44
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,500,000.00	1,358,100.00	141,900.00	90.54
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	31,818,200.00	29,551,600.00	2,266,600.00	92.88
210601	Багаж, техник, хэрэгсэл	16,000,000.00	15,499,600.00	500,400.00	96.87
210604	Урсгал засвар	15,818,200.00	14,052,000.00	1,766,200.00	88.83
2107	Томилолт, зочны зардал	21,000,000.00	20,839,000.00	161,000.00	99.23
210702	Дотоод албан томилолт	21,000,000.00	20,839,000.00	161,000.00	99.23
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	49,246,400.00	40,315,161.00	8,931,239.00	81.86
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	47,296,400.00	38,893,700.00	8,402,700.00	82.23
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	500,000.00		500,000.00	
210804	Тээврийн хэрэгслийн татвар	500,000.00	498,800.00	1,200.00	99.76

**Архангай аймгийн Хангай сумын ЗДТГ-ын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	200,000.00	173,068.00	26,932.00	86.53
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	700,000.00	700,000.00		100
210807	Газрын төлбөр	50,000.00	49,593.00	407	99.19
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	<u>67,000,000.00</u>	<u>27,794,900.00</u>	<u>39,205,100.00</u>	<u>41.48</u>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	60,000,000.00	23,363,100.00	36,636,900.00	38.94
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,000,000.00	4,431,800.00	2,568,200.00	63.31
<b>212</b>	<b>ТАТААС</b>	<b><u>6,000,000.00</u></b>	<b><u>5,822,560.00</u></b>	<b><u>177,440.00</u></b>	<b><u>97.04</u></b>
<b>2122</b>	<b>Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас</b>	<b><u>6,000,000.00</u></b>	<b><u>5,822,560.00</u></b>	<b><u>177,440.00</u></b>	<b><u>97.04</u></b>
212201	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	6,000,000.00	5,822,560.00	177,440.00	97.04
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b><u>28,102,000.00</u></b>	<b><u>20,856,018.28</u></b>	<b><u>7,245,981.72</u></b>	<b><u>74.22</u></b>
2132	Бусад урсгал шилжүүлэг	28,102,000.00	20,856,018.28	7,245,981.72	74.22
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	24,102,000.00	19,746,018.28	4,355,981.72	81.93
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,000,000.00	1,110,000.00	2,890,000.00	27.75
<b>1</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b><u>973,406,900.00</u></b>	<b><u>847,661,343.51</u></b>	<b><u>125,745,556.49</u></b>	<b><u>87.08</u></b>
<b>131</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>				
<b>132</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b><u>958,406,900.00</u></b>	<b><u>806,168,238.51</u></b>	<b><u>152,238,661.49</u></b>	<b><u>84.12</u></b>
132001	Орон нутгийн төсвөөс	958,406,900.00	806,168,238.51	152,238,661.49	84.12
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	15,000,000.00	41,493,105.00	-26,493,105.00	276.62
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	15,000,000.00	41,493,105.00	-26,493,105.00	276.62
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл				
<b>1</b>	<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>				
2	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1		100
5	АЖИЛЛАГСДЫН ТОО	24	23	1	95.8
6	Удирдах ажилтан	9	9		100
7	Гүйцэтгэх ажилтан	8	7	1	87.5
8	Үйлчлэх ажилтан	8	8		100

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Д/Д	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	<b>3,458,110.00</b>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	<b>3,458,110.00</b>
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	<b>3,458,110.00</b>
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,458,110.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,458,110.00
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	<b>3,458,110.00</b>
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	7,933,518.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	6,050,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,883,518.00
	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар 2,574.4 мянган төгрөгийн алдаа илэрснийг аудитын явцад залруулсан. Харин залруулаагүй нийт 11,172.2 мянган төгрөгийн зөрчил<sup>1</sup> илэрснээс 9,012.2 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 4 албан шаардлага, 2,160.0 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоолоо. Аудитаар залруулагдаагүй материаллаг 5 зөрчилтэй асуудал нь **11,172.2** мянган төгрөг бөгөөд гүйцэтгэлийн материаллаг байдлын дүн **6,813.8** мянган төгрөгөөс **их** байгаа тул **Хязгаарлалттай** дүгнэлт өглөө

### 5.1 Төлбөрийн акт

5.1.1 Тайланд онд төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлээс 3,600.0 мянган төгрөгийн 15 тонн нүүрс бэлтгэж нөөцөлсөн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2-т "Төсвийн захирагчийн төсвийн дараах зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн хэмнэлтэд тооцохгүй бөгөөд тухайн үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлнэ" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

### 5.2 Албан шаардлага

5.2.1 Тус байгууллага нь дотоод хяналтын нэгжгүй, тайлант оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт хийж ажиллаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.2-д "Батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоох арга хэмжээ авч ажиллах албан шаардлага хүргүүлээ.

5.2.2 Тус сумын Засаг даргын 2024.07.25-ны өдрийн Б/07, 2024.12.19-ний Б/15 дугаар захирамжаар улс төрийн албан тушаалтанд 6,204.2 мянган төгрөгийн үр дүнгийн урамшуулал, аймгийн Засаг даргын 2024.02.06-ны А/50 дугаар захирамжийн дагуу сумын Засаг даргад 2,808.0 мянган төгрөг, нийт 9,012.2 мянган төгрөгийг цалингийн сангаас олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-т "Хэмнэлтийн горим хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална" 4.1.3-т "үр ашигтай байх", 4.1.6-д "Сахилга баттай байх", 15 дугаар зүйлийн 15.1.3-т "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоож, холбогдох хууль журмыг мөрдөж ажиллах албан шаардлага хүргүүлээ.

5.2.3 Үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэлийг хянаж үзэхэд элэгдлээрээ өртгөө бүрэн нөхсөн машин тоног төхөөрөмжийн дансанд 69 нэр төрлийн 58,146.6 төгрөг, тавилга аж ахуйн эд хогшил дансанд 35 нэр төрлийн 3,957.5 төгрөг, бусад үндсэн хөрөнгө 30 нэр төрлийн 163,169.0 мянган төгрөг, авто тээврийн хэрэгслийн 4 нэр төрлийн 73,244,8 мянган төгрөг нийт 139 нэр төрлийн 298,518.1 мянган төргийн үндсэн хөрөнгө бүртгэлтэй байна.

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Энэ нь ТБОНӨТ хуулийн 31 дүгээр зүйлийн 1-т “Төрийн өмчит хуулийн этгээд эзэмшилдээ байгаа илүүдэл үндсэн эд хөрөнгө, түүнчлэн ашиглах хугацаа нь дууссан буюу эсхүл осол гэмтэлд өртсөний улмаас зориулалтаар нь ашиглах боломжгүй болсон бөгөөд засаж, сэлбэж ашиглах нь эдийн засгийн хувьд үр ашиггүй нь тооцоогоор нотлогдсон эд хөрөнгийг худалдаж, шилжүүлж, акт тогтоон устгаж болно”, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын тогтоол 7 дугаар зүйлийн 7.1-т “Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгах арга хэмжээг авч ажиллах албан шаардлага хүргүүлэв.

5.2.4 Хангай сумын ЗДТГ-ын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төрийн аудитын газарт 2024 оны 01 дүгээр сарын 28-ний өдрийн 3/50 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т “төсвийн шууд захирагч улирлын төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа улирлын эхний сарын 15-ны дотор гаргаж харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид, жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 25-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн санхүүгийн тайланг 02 дугаар сарын 25-ны дотор харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид хүргүүлэх” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоож , ЗДТГ-ын даргад хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлээ.

*Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.*

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Үнэ төлбөргүй ирсэн үндсэн хөрөнгийг үндсэн хөрөнгийн бүртгэлд тусгаагүй	1	2,574.4	1	2,574.4								
Дүн	1	2,574.4	1	2,574.4								

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Үүнээс		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
							Зөвлөмж					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Дотоод хяналт хэрэгжүүлээгүй	1				1							
Улс төрийн албан хаагчдад цалингийн сангаас үр дүнгийн урамшуулал олгосон	1	9,012.2			1	9,012.2						
Элэгдлээрээ өртгөө нөхсөн хөрөнгийг дахин үнэлэх арга хэмжээ аваагүй	1				1							
Төсвийн хэмнэлтээс нүүрс нөөцөлсөн	1	2,160.0	1	2,160.0								
Санхүүгийн тайланг хугацаа хоцроосон	1								1			
<b>Нийт дүн</b>	<b>5</b>	<b>11,172.2</b>	<b>1</b>	<b>2,160.0</b>	<b>3</b>	<b>9,012.2</b>			<b>1</b>			

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Мэдээлэл дутуу байршуулсан		0	-	-		0	-	-
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
						-	-	-